



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 1/01

Арвайхээр

Хэвлэмэл хуудасны индекс
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолын 4.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өвөрхангай аймгийн Татварын хэлтсийн хэрэглэх хэвлэмэл хуудасны нэр төрөл, тэдгээрийн индексийг хавсралтаар баталсугай.

2. Тушаалыг 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс хэрэгжүүлж, мөрдөн ажиллахыг архив, бичиг хэргийн эрхлэгч (Д.Отгонтуяа)-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хуулийн тасгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Ганчимэг)-д тус тус үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙН ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Н.ЭРДЭНЭСУВД



621001001

Өвөрхангай аймгийн Татварын хэлтсийн
даргын 2022 оны 7 сарын 28-ны өдрийн
дүгээр тушаалын хавсралт



ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ХЭВЛЭМЭЛ ХУУДАСНЫ НЭР ТӨРӨЛ,
ТЭДГЭЭРИЙН ИНДЕКС

№	Хэвлэмэл хуудасны нэр төрөл	Хэвлэмэл хуудасны индекс	Хариуцах албан тушаалтан
1	Хэлтсийн даргын тушаал	621001001	Архив, бичиг хэргийн эрхлэгч
2	Албан тоот А4	621002001	
3	Албан тоот А5	621003001	

---oOo---